

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, ЦАХИМ ОРЧИН ДАХЬ ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

*Ч. Гончигсумлаа
Бакалавр оюутан*

*Шинжлэх ухаан, технологийн их сургууль
Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль*

gonchigsumlaa990@gmail.com

Хураангуй: Дэлхий дахинд аж үйлдвэрийн IV хувьсгал эрчимтэй өрнөж, дижитал технологи, тоон системд суурилсан хүмүүс хоорондын харилцааны шинэ сувгууд олноор бий болсон. Тэдгээр харилцааны хэрэгслүүдийг ашиглах хэрэглэгчид нэмэгдэхийн хирээр нийгэмд янз бүрийн асуудлууд үүсэн бий болж байна. Тухайлбал, Монгол улс нийгмийн сүлжээний нэг хэрэгсэл болох фэйсбүүкийн хэрэглээгээрээ Азидаа тэргүүлж, дэлхийд эхний аравт эрэмбэлэгдэж байна. Уламжлалт хэвлэл мэдээллийн хэрэгслүүд дэх контентын агуулга, чанар 5-10 жилийн өмнөх үетэйгээ харьцуулахад олон нийтийн хүсэл сонирхлыг татах тал дээр анхаарч ажиллах шаардлагатай байгааг салбарын тоон үзүүлэлтүүд нь тодорхой илэрхийлж байгаа болно. Үүнийг дагаад Монголын нийгэмд цахим гэмт хэрэг, цахим хүчирхийлэл зэрэг асуудлууд урган гарч, насанд хүрээгүй хүүхдүүд тэрхүү асуудлын хохирогч болох явдал жил бүр нэмэгдэж байгааг мэргэжлийн байгууллагууд онцолж байна. Тиймээс нийгмийн бүхний л салбарынхан хэвлэл мэдээлэл, цахим орчин дахь хүүхэд хамгааллын асуудалд анхаарал хандуулах, хүүхдийн хамгийн чухал хүмүүжлийн орчин болох гэр бүлийн орчинд эцэг эх ямар үүрэгтэйгээр хүүхдээ хүмүүжүүлэх, асуудлаас хэрхэн гарах, хэрхэн урьдчилан сэргийлэх боломж нөхцөл байгааг онол практикийн хувьд судлах, хэрэгжихүйц гарц шийдлүүдийг нийгэмд танилцуулах шаардлагатай гэж үзэн тус судалгааг хийж гүйцэтгэв.

Түлхүүр үгс: Арга зам, сайн туршлага, боломж, үүрэг, уриалга

УДИРТГАЛ

Судалгааны үндэслэл: Олон улсын судалгааны байгууллагуудын тодорхойлсноор Монгол улсын нийт хүн амын 70 хувь нь нийгмийн сүлжээ тэр дундаа фэйсбүүкийг идэвхтэй ашигладаг. Тиймээс нийгмийн хөгжлөө дагаад уламжлалт мэдээллийн хэрэгслүүд цахим шилжилт хийх хандлага нэмэгдэж, зорилтот бүлгүүд рүү чиглэсэн контентын хүртээмж, чанар, давтамж буурч байна. Үүнээс үүдэн манай улсын 14-19

насны 480 мянга гаруй хүүхэд залуучуудын 90 хувь нь нийгмийн сүлжээг өөрсдийн чөлөөт цагаа өнгөрүүлэх талбар болгон ашиглаж байгааг судалгааны тоо баримт тодорхой харуулна. Тэдгээр хүүхэд залуучууд өөрсдийн санамсаргүй байдлаасаа болж цахим орчинд гутаан доромжлуулах, цахим гэмт хэргийн хохирогч болох, хувийн нууцаа алдах, нийгмээс өөрийгөө тусгаарлах, буруу дадал хэвшилд уруу татагдах, баталгаагүй мэдээлэлд итгэх, төөрөгдөх зэрэг асуудлууд нийгэмд олноор гарах

боллоо. Түүнчлэн хүүхдүүдээс гадна насанд хүрэгчид нийгмийн сүлжээнд донтох, ихэнх цаг заваа дэлгэцний ард өнгөрүүлэх, гэр бүлийнхэнтэйгээ цахимаар дамжуулж харилцах хандлага ихсэж байгаа нь хэвлэл мэдээлэл, цахим орчин дахь хүүхэд хамгааллын асуудлыг судлах, эцэг эхчүүдийн үүрэг оролцоог хэрхэн ямар түвшинд байгааг тодорхойлох, асуудлыг шийдвэл зохих ямар боломжит аргууд байгааг судлан шинжлэх шаардлагатай юм.

Судлагдсан байдал: Цахим орчин дахь хүүхэд хамгааллын тухай Цагдаагийн Ерөнхий газар, чөлөөт уран бүтээлчид, сэтгүүлчид, хүүхдийн эрхийн байгууллагууд хайгуул судалгаа өрнүүлж, судалгаанд суурилсан урьдчилан сэргийлэх уулзалт, хэлэлцүүлэг, илтгэл, товхимол зэргийг олон нийтэд хүргэж байна. Гэхдээ хэвлэл, мэдээлэл, цахим орчин дахь хүүхэд хамгааллын асуудалд нөлөөлөх хүчин зүйлийг тодруулах, цахим орчны сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сайн туршлагын талаар судалсан мэдээлэл баримтууд нийтэд түгээмэл биш байгаа нь судалгааны явцад ажиглагдсан.

Судалгааны зорилго, зорилт: Хэвлэл мэдээлэл, цахим орчин дахь хүүхэд хамгааллын асуудлыг бий болгож буй хүчин зүйлсийг тодорхойлох, гарц шийдлийг боловсруулахад оршино. Зорилгоо ханган биелүүлэхийн тулд дараах зорилтуудыг тулгуур болгоно.

1. Хэвлэл мэдээлэл, цахим орчин дахь хүүхэд хамгааллын асуудал үүсэн бүрэлдэхэд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох

2. Хэвлэл мэдээлэл, цахим орчин дахь хүүхэд хамгааллын асуудлыг шийдвэрлэх, сайжруулахад чиглэсэн сайн туршлагыг судлах

3. Хэвлэл мэдээлэл, цахим орчин дахь хүүхэд хамгааллын асуудлыг шийдвэрлэх гарц шийдлүүдийг тодорхойлох

Судалгааны арга: Баримт бичгийн арга, контент анализын аргуудыг тус тус ашиглана.

Судалгааны ажлын шинэлэг тал, ач холбогдол: Хэвлэл мэдээлэл, цахим орчин дахь хүүхэд хамгааллын асуудлыг шийдвэрлэхэд гэр бүлийн орчин дахь харилцаа, эцэг эхчүүдийн үүрэг оролцоо ямар түвшинд байх тал дээр гол анхаарлаа хандуулж, сайн туршлагыг судлан танилцуулж байгаагаараа онцлогтой. Энэхүү судалгааны ажлыг хийж гүйцэтгэснээр цахим орчин дахь хүүхэд хамгааллын асуудлыг гүнзгийрүүлэн судлахад хайгуул судалгааны баримт бичиг болох, хэвлэл, мэдээлэл, цахим орчин дахь хүүхэд хамгааллыг сайжруулахад үүрэг хүлээгч талуудын оролцоо ямар түвшинд байгаа эсэх, практик дахь асуудлаа бодитоор харахад эх сурвалж зэрэг олон талын ач холбогдолтой.

Судалгааны ажлын бүтэц: Хураангуй, оршил, үндсэн хэсэг,

дүгнэлт, ном зүй, ашигласан эх сурвалжууд

Нэг. Хэвлэл мэдээлэл, цахим орчин дахь хүүхэд хамгааллын асуудал үүсэн бүрэлдэхэд нөлөөлөх хүчин зүйлс

Асуудлын нөлөөлөгч хүчин зүйлсийг тодорхойлохдоо баримт бичгийн арга, контент анализын аргыг ашиглалаа. Дээрх аргуудыг ашиглан хийгдсэн судалгааны үр дүнг нэгтгэн танилцуулъя.

Уламжлалт мэдээллийн хэрэгслүүд дэх хүүхдэд зориулсан контентын тоо, чанар буурч, ухаалаг утас хэрэглэгчдийн тоо нэмэгдсэн. Улсын хэмжээнд нэвтрүүлгээ цацдаг 45 телевизийн хөтөлбөрт анализ хийхэд МҮОНРТ-ын “Мааму”, TV8 телевизийн “Найзууд”, TV9 телевизийн “Бүнээ сүнээ”, ТМ телевизийн “Зу-зу”, Монгол HD телевизийн “Тог-тог-тог” зэргээс өөр хүүхдийн нэвтрүүлгүүд байхгүй байгаа төдийгүй хүүхдэд чиглэсэн контентийн ихэнх хувийг хүүхэдэд кино эзэлж байна. Дээрх хүүхдийн нэвтрүүлгүүд өөрсдийн сувгаар хүүхдүүдэд хүрч байгаа ч тогтмол цагт гардаггүй тул цар хүрээ, хүртээмж нь хязгаарлагдмал байдаг. Харилцаа холбооны зохицуулах хорооноос хийсэн судалгаагаар хүүхдүүд киноны moviebox, asianbox, sky TV сувгийг хамгийн их үздэг боловч,

эдгээр сувгуудад хүүхдэд зориулсан нэвтрүүлэг огт гардаггүй.²⁶ Боловсрол, соёл, хэвлэл мэдээллийн салбарын салбар дундын уулзалт хэлэлцүүлгээр ч хүүхдийн нэвтрүүлгийн агуулга, хүртээмж маш хангалтгүй түвшинд байгааг онцолсоор байна. БСШУЯ-аас хийсэн судалгаагаар улсын хэмжээнд нийт сурагчдын 94% ухаалаг утас ашигладаг ба Улаанбаатар хотын нийт сурагчдын 70%, хөдөө орон нутгийн сурагчдын 63.6% нь фэйсбүүкээс голчлон мэдээллээ авдаг нь тогтоогджээ. Түүнчлэн MMGG компанийн судалснаар манай улсын 15-20 насны иргэдийн 95 хувь нь ухаалаг утас ашигладаг.²⁷ Энэ нь хүүхдүүд ухаалаг утсыг ашиглан хэвлэл мэдээллийн хэрэгслүүд дэх баталгаатай эх сурвалж бүхий мэдээллээр хангагдахаас илүүтэй нийгмийн сүлжээний янз бүрийн мэдээлэлтэй танилцах нь хялбар хэмээн ойлгож буйн илрэл гэж хэлж болох юм.

Гэр бүлээрээ үзэх контент хөтөлбөр түгээмэл байхгүй нь нийгмийн сүлжээний хэрэгслийг сонгох суурь шалтгаан болж байна. Юнивишн, Скай медиагийн видео санд гэр бүлийн контент хөтөлбөр байдаг ч контентийн төлбөр, үйлчилгээний цар хүрээнээс шалтгаалан хүссэн хүн бүр үзэх, сонсох боломжгүй байгаа юм.

²⁶ “Цахим орчны зохистой хэрэглээ”-таны хүүхдийг танихгүй хүн хүмүүжүүлж байна илтгэл, Харилцаа холбооны зохицуулах хороо, УБ., 2018

²⁷ <http://gogo.mn/r/222884> “Монголд ухаалаг гар утас хэрэглэгчдийн тоо 1.7 саяд хүрсэн” мэдээнээс...

Улсын хэмжээнд нэвтрүүлэг, нийтлэлээ цацдаг мэдээллийн хэрэгслүүдийн хөтөлбөрт шинжилгээ хийж үзэхэд гэр бүлийн гишүүн бүрт зориулсан агуулга бүхий тусгай контент байхгүй байна. Энэ нь хэвлэл мэдээллийн хэрэгслээс илүү цахим орчинд сонирхол татсан мэдээлэл байдаг гэсэн хандлагыг төрүүлж, нийгмийн сүлжээг ашиглах сонголтыг хийхэд хүргээд байна.

Эцэг эхчүүд өөрсдөө нийгмийн сүлжээний идэвхтэй хэрэглэгчид болж, үр хүүхдэдээ цахим орчинг ашиглах сонголтыг бий болгож өгч байна. Олон улсын байгууллагуудын судалгаанаас харахад Монгол улсад 2.2 сая идэвхтэй фэйсбүүк хэрэглэгч байна. Тэдний 2.1 сая нь утсаараа интернетэд холбогддог.²⁸ Нийслэлийн иргэдийн 84 хувь, орон нутгийн иргэдийн 77 хувь нь фэйсбүүкийг өөрсдийн амьдралын өдөр тутмын хэвшил болгосон. Энэ нь манай улсын 15-60 насны 10 хүн тутмын 8 нь фэйсбүүкийг идэвхтэйгээр ашиглаж байна гэсэн үг.²⁹ Дээрх судалгаануудаас үзэхэд эцэг эхчүүдийн дийлэнх нь фэйсбүүкийг идэвхтэй ашиглаж байна. Гэвч манай улсад тэр дундаа эцэг эхчүүд өөрсдийн үр хүүхдэд хэвлэл мэдээлэл, цахим орчны зөв

зохистой хэрэглээг сургах, түгээн дэлгэрүүлэх ажил учир дутагдалтай байгаа нь энэ чиглэлийн олон хэлэлцүүлэг, ярилцлагуудад дурдагджээ. Тэгэхээр хүүхдүүд эцэг эхээ даган дуурайх аль эсвэл цахим орчинг ашиглах шаардлагатай гэж ойлгосон хандлагаараа нийгмийн сүлжээнд дийлэнх цагаа зарцуулах сонголтыг хийдэг хэмээн үзэж болохоор байна.

Эцэг эхчүүд хүүхдийнхээ хэвлэл, мэдээлэл, цахим орчноос авч буй мэдээлэлд цензур тавьдаггүй, зохистой хэрэглээг төдийлөн сурталчилдаггүй, хараа хяналт сул байгаа хандлага түгээмэл байна. Манай судлаачдын үзэж буйгаар цахим орчин дахь 10 мэдээлэл тутмын 8 нь тухайн хүүхдийн нас, бие сэтгэхүйн онцлогт тохирохгүй агуулга байгаа бөгөөд энэ нь эрсдэлийг бий болгож, хүүхдийг буруу мэдээллээр хангаж, зохисгүй харилцаанд оролцоход нөлөө үзүүлж байгаа аж.³⁰ Монгол улсын 21 аймаг, есөн дүүргийн төлөөллийг оролцуулсан “Өсвөр үе ба цахим хэрэглээ” үндэсний судалгаанд хамрагдсан 378 эцэг эх, 404 багш нийгмийн ажилтнуудын 41 хувь нь хүүхдээ интернет орчинд ямар сайтаар зочилсон, ямар мэдээлэлтэй харилцсан талаар огт мэдэхгүй³¹

²⁸

<https://napoleoncat.com/stats/facebook-users-in-mongolia/2019/11>

²⁹ <http://eagle.mn/г/61517> Ийгл телевиз “Интернет, сошиал медиа, дэлхий ба бид” сурвалжлага, 2019 оны долдугаар сар

³⁰ “Нийгмийн сүлжээ ба зохистой хэрэглээ” үндэсний форумын тэмдэглэл, 2019 оны дөрөвдүгээр сар

³¹ Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар “Өсвөр үе ба цахим хэрэглээ” үндэсний судалгааны тайлан, УБ., 2019 он сар

хэмээх хариултыг өгсөн нь хүүхдүүд цахим орчин дахь мэдээллийг эцэг эхийн зөвлөгөө ярилцлагаас илүү үнэн бодит, итгэлтэй гэж хандаж буйн илрэл юм.

Гэр бүлийн орчинд эцэг эхчүүдийн үр хүүхэдтэйгээ харилцах амьд харилцаа дутагдаж, хэвлэл мэдээлэлтэй харилцах, цахим орчинг ашиглах зэргээр хамтын бус бие даасан харилцаа өрнөх явдал ихсэж байна. Гэр бүлийн гишүүн бүр өөрсдийн үзэл бодол, асуудал мэдрэмжээ амьд харилцаагаар бие биедээ илэрхийлэхээс илүүтэй нийгмийн сүлжээнд лайк дарах, сэтгэгдэл бичих, шейр хийх зэргээр илэрхийлэх байдал нийгэмд тархсан гэдэгтэй хүн бүр санал нийлнэ. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын мэдээлж байгаагаар нэг Монгол хүн фэйсбүүкт сард дунджаар таван сэтгэгдэл бичиж, 16 пост дээр лайк дарж, гурван пост шейр хийж, 12 сурталчилгааны мэдээлэл үзэж сонирхдог. Энэ нь хүмүүс хоорондын харилцаа амьдчилал гэхээс илүүтэй дэлгэцээр дамжуулж илэрхийлэх хамтын бус харилцаа хөгжөөд байгааг илтгэж байна. Түүнчлэн 24 хүртэлх насныхан уран сайхны кино сериал, 55-с дээш насныхан мэдээ, 25-34 насныхан цэнгээнт нэвтрүүлэг, 35-

44 насныхан нийгмийн шинжтэй нэвтрүүлэг, хэлэлцүүлэг үзэх зэрэг өөр өөрийн хүсэл сонирхолтой байдгийг судалгаагаар тогтоожээ.³² Энэхүү баримт гэр бүлийн гишүүн бүрт хамтдаа үзэж сонсох сонирхолтой контент дутмаг байгааг, эцэг эх, хүүхдүүд өөрсдийн хүссэн л нэвтрүүлгээ үзэж, гэр бүлийн орчинд хамтын бус харилцаа үүсгэж байгааг илтгэсэн тооцоо мэдээлэл хэмээн ойлгож болно. Максима компанийн хийсэн “2018 оны телевизийн үзэгчдийн судалгааны тайлан”-тай³³ танилцахад Яг түүн шиг, Voice, Авьяаслаг Монголчууд зэрэг шоу хөтөлбөрүүд цацагдаж байх үед телевизийн үзэгчдийн насны үзүүлэлт жигд өсөлттэй байсан байна. Тодруулбал, эдгээр шоу нэвтрүүлгүүд “Гэр бүлийн контентууд хүүхэд, эцэг эх, ах эгч, найз нөхөд гээд тухайн гэр бүлийн гишүүн бүр хамтдаа чөлөөт цагаа өнгөрүүлэх, нэвтрүүлгийн талаар санал бодлоо солилцон амьд харилцаа үүсгэх, цахим орчноос бага хоромд ч татгалзах” зэрэг халуун дулаан уур амьсгал бүрдүүлж болдог гэдгийг батлан харуулжээ.

³² *Хэвлэлийн хүрээлэнгийн Мэдээлэл судалгааны алба, “Хэвлэл мэдээлэл хэрэглэгчдийн судалгаа”, УБ., 2015 он*

³³ <https://maxima.mn/2018-tam-tailan/>

Хүснэгт 1. Телевизээр ихэвчлэн ямар төрлийн нэвтрүүлдэг үздэг эсэхийг насаар ангилж харуулсан байна. “2015 оны телевизийн үзэгчдийн судалгааны тайлан”

	24-34	35-44	45-54	55+
	түүхэлтэс нас	нас	нас	дүүдэлтэс нас
Үрэн сайны кино, сөрөг	67%	57%	56%	38%
Мэдээ	26%	25%	25%	16%
Дэвшилгүй, тэмцэл	17%	16%	14%	11%
Нөмөрөн дэвсгэртэй нэвтрүүлэг, хэлэлцүүлэг	6%	8%	10%	14%
Цэцэглэн болон уралдаант нэвтрүүлэг, шоу	19%	20%	11%	9%
Дуу хөгжим	19%	7%	8%	4%
Спортын нэвтрүүлэг	19%	13%	7%	9%
Танин мэдээлэл нэвтрүүлэг	11%	14%	12%	7%
Хүүхдийн нэвтрүүлэг	1%	1%	2%	0%

Гэр бүлийн гишүүн бүр цахим орчин, хэвлэл мэдээллийг хэрхэн зөв зохистой ашиглах талаар мэдээлэл хомс, хүүхдүүд цензургүй мэдээлэлд төөрөгдөж ёс суртахууны хувьд сөрөг зан авиртай болох, итгэмтгий зан чанараасаа болж хүчирхийллийн хэлбэрүүдэд өртөх, хохирогч болох асуудал жил ирэх тусам өссөн үзүүлэлттэй байна. Эцэг эхчүүдийн дийлэнх нь нийгмийн сүлжээнд өөрийгөө хамгаалах чадваргүй байгаа тухай энэ төрлийн олон судалгааны дүгнэлтэд тодорхой тайлбарласан байдаг. Мөн эцэг эхчүүд хүүхдээ утсаар хэт удаан оролдох, телевиз их үзэх нь буруу гэх ойлголтыг зааварлачихаас хэвлэл мэдээлэл, цахим орчинг хэт замбараагүй ашиглах нь бие махбод, сэтгэл санаа, бэлгийн хүчирхийлэлд өртөх эрсдэлийг дагуулах, сэтгэцийн хувьд асуудалтай болох, дэлгэцэд донтох, цагийг үр ашиггүй өнгөрүүлж өөрийгөө хохироох зэрэг олон сөрөг тал урган гарах талаар зөвлөж чадах хэмжээнд ойлголтугүй байгааг судалгааны тайлангууд болон

туршилт, ажиглалтын судалгааны үр дүн тодорхой харуулж байна. Гэтэл зарим хэвлэл мэдээллийн хэрэгслүүд болон цахим орчинд дуучин Т.Дэлгэрмөрөн эхнэрээсээ саллаа, УИХ-ын гишүүн Д.Гантулга хүчингийн хэрэг үйлдлээ, дөрвөн настай хүүхдийг заазуурдаад хөнөөлөө, дуучин Болд Чулуунчимэг, Мөнгөнцэцэг гурвын хайрын гурвалжин өрнөж байна, хөдөөний оркууд хотоос зайл, замын түгжрэл үүсгэсэн соёлгүй жолооч нар үх, зам тээврийн осол гарч газар дээрээ олон хүн нас барлаа, сургуулийн хүүхдүүд амиа хорлож байна, гэх мэт ямар ч цензургүй, зарим тохиолдолд үнэн бодитой эсэх нь тодорхойгүй мэдээлэл цацагдаж, бүх насныхан доорх мэдээллүүд дээр хараасан, зүхсэн, гутаасан сэтгэгдлүүд үлдээж байна. “Өсвөр үе ба цахим хэрэглээ” үндэсний судалгаанд хамрагдсан 2240 хүүхдийн 43 хувь нь садар самууныг сурталчилсан агуулга бүхий мэдээлэлтэй тааралддаг хэмээн хариулжээ.³⁴ Дээрх мэдээллүүд хүүхдүүдийн ёс суртахуун, зан авирт сөрөг нөлөө үзүүлж, ёс бус үг хэллэг хэлэх, хүнийг гутаан доромжлохыг сургах зэргээр олон муу үр дагаврыг бий болгох үндэс суурь болж байна.

Гурав. Хэвлэл мэдээлэл, цахим орчин дахь хүүхэд хамгааллын асуудлыг сайжруулах,

³⁴ <https://news.zindaa.mn/2oew>
 “Нийгмийн сүлжээ ба зохистой хэрэглээ” үндэсний форумын мэдээнээс, УБ., 2019 он

шийдвэрлэхэд чиглэсэн сайн туршлагыг судлах

Цахлай төсөл- Ухаалаг утсанд суулгасан программын тусламжтайгаар эцэг эхчүүд хүүхдийнхээ байршлыг тогтоох, хүүхдэд эрсдэл учирсан үед эцэг, эхэд нь дохиолол ирж, байршлыг нь мэдэгдэх, интернетийн орчинд хүүхдэдээ хараа хяналт тавих, насанд хүрэгчдэд зориулсан утга агуулгатай мэдээллийн сайтад нэвтрэх, зарын чанартай группүүд ашиглах зэрэг тохиолдлуудад эцэг эхийн зөвшөөрөлтэйгөөр нэвтрэх технологийн шийдэл юм. Нийслэлийн дүүргүүдэд төслийн үр дүн маш сайн байгааг албаныхан дурдсан байна.

Шүүлтүүрийн программ, эцэг эхийн хяналт- Харилцаа холбооны зохицуулах хорооноос нэвтрүүлээд буй энэхүү программ нь хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохируулан урьдчилан оруулсан “түлхүүр үг” бүхий онлайн контентийг хаах, +18 болон бусад төрлийн мэдээ мэдээллийг сонгон хязгаарлах, социал медиа болон бусад шаардлагагүй гэж үзсэн сайтын хандалтыг хязгаарлах боломжтой.

Ekids.mn, happywebs.mn сайт - Энэхүү сайтуудаар дамжуулан цахим орчны ёс зүйтэй хэрэглээг сурталчлан таниулах, өсвөр залуу үеийг цахим орчинд өөрийгөө хэрхэн хамгаалах, эцэг эхчүүд цахим аюулгүй байдлаас

хүүхдээ хамгаалахын тулд ямар мэдлэгтэй байх, гэр бүлийн орчинд эцэг эхчүүд цахим хэрэглээний зөв зохистой хэрэглээг хэрхэн төлөвшүүлэх, нийгмийн сүлжээний эерэг болон сөрөг үр дагаврын талаар зааж сургах агуулга бүхий нийтлэлүүдийг хүргэж байна. Жишээ нь хамгийн сүүлд “Зөвийг түгээ, сайныг дэмж”, “Нийгмийн сүлжээнд зөв байцгаая” зэрэг маш сонирхолтой, бүх насныхан уншихад ойлгомжтой, агуулга сайтай нийтлэлүүд нийтлэгджээ.

Танихгүй хүн таны хүүхдийг хүмүүжүүлж байна хэлэлцүүлэг, давлагаа- Цахим орчинд хүүхдүүд дур зоргоороо хяналтгүй байснаас, эцэг эхчүүд хүүхдээ хяналтгүй орхигдуулснаас, гэр бүлийн орчинд цахим хэрэглээ хэт задгайрнаас үүссэн бодит жишээ, үүсэж болох сөрөг үр дагавар, өөрийгөө хамгаалах арга, фэйсбүүкийн заавал мэдэх тохиргоонууд зэрэг уран сайхны бөгөөд сургамжит контентууд хэвлэл, мэдээллийн хэрэгсэл болон цахим орчноор хүчтэй давлагаалсан нь харах, сонсох, сэтгэл зүйгээрээ мэдрэх мэдрэмжүүдээр дамжуулан хүүхдүүдэд, насанд хүрэгчдэд ойлголт мэдээлэл өгч чадсан.

Unfriend хөдөлгөөн- Цахим гэмт хэргээс сэргийлэх энэ хөдөлгөөн давхардсан тоогоор 6.1 сая хүнд хүрсэн дүнтэй байна.³⁵ Үүнээс нэг хүн хамгийн багадаа 100 танихгүй найз, хуурамч хаягийг

³⁵ <https://news.caak.mn/view/8279499/>

unfriend хийсэн буюу найзын жагсаалтаа хасаж, өөрийгөө ерсдэлээс хамгаалсан байна.

Дөрөв. Хэвлэл мэдээлэл, цахим орчин дахь хүүхэд хамгааллын асуудлыг шийдвэрлэх гарц шийдлүүдийг тодорхойлох

3.1. Эцэг эхчүүд хүүхдээ дэлгэцний донтолтоос хамгаалах үүргээ сайтар биелүүлэх. “Хүүхэд дэлгэц ашиглах тохиромжтой хугацаа”-ны мэдээллийг эцэг эхчүүдэд сурталчлах, гэр бүлийн орчинд хүүхдээ дэлгэцний хор нөлөө, донтолтоос хамгаалах хяналтын арга хэмжээ авч байхыг уриалах

3.2. Зохистой хэрэглээг түгээн дэлгэрүүлэх ажлыг эрчимжүүлэх, эцэг эхчүүдэд цахим аюулгүй байдлын талаар мэдээлэл сурталчилгааг давтамжтайгаар хүргэх. Эцэг эхчүүд өөрсдөө аюулгүй байдал, үүсэх үр дагавар, урьдчилан сэргийлэх зохистой хэрэглээний талаар төдийлөн сайн ойлголцогүй байгаа учраас хүүхдийнхээ хүртэж буй мэдээллийн агуулгад хяналт тавих, зөвлөн туслах тал дээр учир дутагдалтай байсаар л байна. Тиймээс гэр бүлийн гишүүн бүрт зохистой зөв хэрэглээг ойлгуулах, хэвлэл мэдээлэл, цахим орчин дахь харилцааны хохирогч болохоос нь

урьдчилан сэргийлэх ажлыг олон удаагийн давтамжтай зохион явуулах нь зүйтэй.

3.3. Гэр бүлийн орчинд хэвлэл мэдээлэл, цахим орчинтой харилцах тодорхой цагийн бүс тогтоох тухай арга хэмжээнүүд зохион байгуулах. Эцэг эхчүүд өөрсдөө хүүхэдтэйгээ хамт медиа хэрэгслүүдийн идэвхтэй хэрэглэгч байх энэ хандлагыг өөрчлөхгүй бол гэр бүлийн орчин дахь хүүхэд хамгааллын асуудал шийдвэрлэхэд улам төвөгтэй болно. Тиймээс эцэг эхчүүдэд тодорхой хугацааг мэдээллийн орчинд зарцуулах цагийн бүс тогтоож, үлдсэн цаг хугацаагаа хүүхэдтэй ярилцах, ойлголцох, зөвлөхөд зарцуулах шаардлага гэдгийг сайтар ухамсарлан ойлгуулах хэрэгтэй.

3.4. Эцэг эхчүүд хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж, гэр бүлийн орчиндоо үлгэрлэгч байх зарчмыг мөрдлөг болгох. Монгол улсын гэр бүлийн тухай 26 дугаар зүйлд эцэг эхчүүд хүүхдээ хүмүүжүүлэх үүргийг тодорхой заасан байдаг.³⁶ Хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхэд эцэг эхчүүдэд хандлага, сэтгэл чухал юм. Хүүхдээ сэтгэхүйн хувьд төлөвшүүлэх үүрэгтээ атлаа гэр бүлийн орчинд цаг заваа дижитал орон зайд зарцуулаад байвал хүүхэд хэрхэн

³⁶ 26.2.1.хүүхдээ эрүүл чийрэг өсгөн бойжуулах, сэтгэхүйн хувьд төлөвшүүлэх; 26.2.2.хүүхдээ асран хамгаалах, тэжээн тэтгэх; 26.2.3.хүүхдээ үндэсний ёс заншил, уламжлалаа дээдлэх үзлээр хүмүүжүүлэх, түүнд суурь боловсрол эзэмшүүлэх,

хөдөлмөрийн анхны дадлага олгох; 26.2.4.хүүхдийн эрхийг хамгаалж, үүргээ биелүүлэхэд нь туслах үүрэгтэй.

өсөж, хүмүүжих нь тодорхой. Тиймээс хэвлэл мэдээлэл, цахим орчинд хүүхдээ эрсдэлт үйлдлээс хамгаалах, асуудал тулгарсан үед шийдвэрлэхэд

3.5. Хүүхэд, хамгааллын тухай хуулийн 8 дугаар зүйлд хүүхдэд зориулсан тусгай контентийг бүтээх, нэвтрүүлэх, түгээх талаар нэмэлтээр тусгах

3.6. Хэвлэл, мэдээлэл, цахим орчин дахь хүүхэд хамгааллын тухай 8 дугаар зүйлийн 8.1-р зүйлд сургуулийн орчинд хэвлэл, мэдээлэл, цахим орчинд насанд хүрээгүй хүүхдийг хамгаалахад ямар үүрэг хүлээхийг тодорхой зааж өгөх

3.7. Бусад хууль тогтоомжийг сурталчлах. Хувь хүний нууцын тухай хууль, зөрчлийн тухай хууль, эрүүгийн тухай хуульд хэвлэл, мэдээлэл, цахим орчинд бусдыг гутаан доромжлох, гүтгэх, садар самууныг сурталчлах, худал мэдээлэл өгөх, тараах, хувь хүний нууцыг задруулах зэрэг үйлдлүүдэд хүлээлгэх хариуцлагыг тодорхой заасан байдаг. Тиймээс манай улсад цахим харилцааг зохицуулах эрх зүйн зохицуулалт байхгүй гээд хариуцлагаас мултрах боломжгүйг сайтар ойлгуулах

ДҮГНЭЛТ

Хэвлэл мэдээлэл, цахим орчин дахь хүүхэд хамгааллын асуудлыг бий болгож буй хүчин зүйлсийг тодорхойлох, гарц шийдлийг боловсруулах зорилгын

хүрээнд 3 зорилтоор судалгааг гүйцэтгэж, дараах дүгнэлтүүдийг хийж байна.

1. Хэвлэл мэдээлэл, цахим орчин дахь хүүхэд хамгааллын асуудал үүсэн бүрэлдэхэд нөлөөлж буй хүчин зүйлсийг судлан уламжлалт мэдээллийн хэрэгслүүд дэх хүүхдэд зориулсан контентийн тоо, чанар буурч, ухаалаг утас хэрэглэгчдийн тоо нэмэгдсэн, гэр бүлээрээ үзэх контент хөтөлбөр түгээмэл байхгүй нь нийгмийн сүлжээний хэрэгслийг сонгох суурь шалтгаан болж байгаа байдал, эцэг эхчүүд өөрсдөө нийгмийн сүлжээний идэвхтэй хэрэглэгчид болж, үр хүүхдэдээ цахим орчинг ашиглах сонголтыг бий болгож өгч байгаа явдал, эцэг эхчүүд хүүхдийнхээ хэвлэл, мэдээлэл, цахим орчноос авч буй мэдээлэлд цензур тавьдаггүй, зохистой хэрэглээг төдийлөн сурталчилдаггүй, хараа хяналт сул байгаа хандлага, гэр бүлийн орчинд эцэг эхчүүдийн үр хүүхэдтэйгээ харилцах амьд харилцаа дутагдаж, хэвлэл мэдээлэлтэй харилцах, цахим орчинг ашиглах зэргээр хамтын бус бие даасан харилцаа өрнөх явдал ихсэж байгаа байдал, гэр бүлийн гишүүн бүр цахим орчин, хэвлэл мэдээллийг хэрхэн зөв зохистой ашиглах талаар мэдээлэл хомс, хүүхдүүд цензургүй мэдээлэлд төөрөгдөж ёс суртахууны хувьд сөрөг зан авиртай болох, итгэмтгий зан чанараасаа болж хүчирхийллийн хэлбэрүүдэд өртөх, хохирогч болох асуудал жил

ирэх тусам өссөн үзүүлэлттэй байгаа зэрэг нөхцөлүүдийг хүүхэд хамгааллын үүсэн бүрэлдэхэд голлох нөлөө үзүүлж буй хүчин зүйлс хэмээн тодорхойллоо.

2. Цахлай төсөл, шүүлтүүрийн программ, эцэг эхийн хяналт, ekids.mn, гэр бүлдээ цаг гаргая уриалга, танихгүй хүн таны хүүхдийг хүмүүжүүлж байна хэлэлцүүлэг, давлагаа, unfriend хөдөлгөөн зэрэг үйл ажиллагаануудаар дамжуулан хэвлэл мэдээлэл, цахим орчин дахь хүүхэд хамгааллын асуудлыг үр дүнтэй шийдвэрлэж, гэр бүлийн орчинд эцэг эхчүүд, үр хүүхдэдээ үлгэрлэн дуурайлагч байх, зохистой хэрэглээг хэвшүүлэх ойлголт мэдээллийг үр дүнтэйгээр сурталчилж чадсан сайн туршлагууд манай улсад олон байна.

3. Хэвлэл мэдээлэл, цахим орчин дахь хүүхэд хамгааллын асуудлыг шийдвэрлэх үндсэн чухал арга зам бол “Эцэг эхчүүд гэр бүлийн орчинд дэлгэцний донтолтоос ангижирж, амьд харилцаа үүсгэж, цахим аюулгүй байдлын талаар хүүхдүүдийнхээ зөвлөн туслагч нь байх” буюу гэр бүлийн орчин дахь эцэг эхчүүдийн хандлага, оролцоо гэж үзэж байгаа юм. Мөн Эцэг эхчүүд хүүхдээ дэлгэцний донтолтоос хамгаалах үүргээ сайтар биелүүлэх, зохистой хэрэглээг түгээн дэлгэрүүлэх ажлыг эрчимжүүлэх, эцэг эхчүүдэд цахим аюулгүй байдлын талаар мэдээлэл сурталчилгааг

давтамжтайгаар хүргэх, гэр бүлийн орчинд хэвлэл мэдээлэл, цахим орчинтой харилцах тодорхой цагийн бүс тогтоох тухай арга хэмжээнүүд зохион байгуулах, эцэг эхчүүд хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж, гэр бүлийн орчиндоо үлгэрлэгч байх зарчмыг мөрдлөг болгох, технологийн шийдлийг өргөнөөр нэвтрүүлэх, салбар дундын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, хэвлэл мэдээллийн хэрэгслүүд дэх гэр бүлийн болон хүүхдэд зориулсан чанартай контентийг бий болгох, тогтмол нийтлэх, нэвтрүүлэх, хүүхэд, хамгааллын тухай хуулийн 8 дугаар зүйлд хүүхдэд зориулсан тусгай контентийг бүтээх, нэвтрүүлэх, түгээх талаар нэмэлтээр тусгах, хэвлэл, мэдээлэл, цахим орчин дахь хүүхэд хамгааллын тухай 8 дугаар зүйлийн 8.1-р зүйлд сургуулийн орчинд хэвлэл, мэдээлэл, цахим орчинд насанд хүрээгүй хүүхдийг хамгаалахад ямар үүрэг хүлээхийг тодорхой зааж өгөх, бусад хууль тогтоомжийг сурталчлах зэрэг арга замуудыг хэвлэл мэдээлэл, цахим орчин дахь хүүхэд хамгааллын асуудлыг шийдвэрлэх гарц шийдлүүд хэмээн үзлээ.

НОМ ЗҮЙ

1. Харилцаа холбооны зохицуулах хороо “Цахим орчны зохистой хэрэглээ” Уб.,2018
2. Харилцаа холбооны зохицуулах хороо, Хууль зүй, дотоод хэргийн яам, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар “Нийгмийн сүлжээ ба зохистой хэрэглээ-2019” форум, мэдээллийн эмхэтгэл Уб.,2019

4. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар “Өсвөр үе ба цахим хэрэглээ” үндэсний судалгааны тайлан, УБ.,2019 он
5. Хэвлэлийн хүрээлэнгийн Мэдээлэл судалгааны алба, “Хэвлэл мэдээлэл хэрэглэгчдийн судалгаа”, УБ.,2015
6. <http://gogo.mn/r/222884> “Монголд ухаалаг гар утас хэрэглэгчдийн тоо 1.7 саяд хүрсэн”
7. <http://eagle.mn/r/61517> Ийгл телевиз “Интернет, социал медиа, дэлхий ба бид” сурвалжлага, 2019 оны долдугаар сар
8. www.maxima.mn 2018 оны телевиз үзэгчдийн судалгааны нэгдсэн тайлан
9. <https://news.zindaa.mn/2oew> “Нийгмийн сүлжээ ба зохистой хэрэглээ” үндэсний форумын мэдээнээс, УБ.,2019 он
10. <https://news.caak.mn/view/8279499/> www.napoleoncat.com Facebook users in Mongolia in November 2019